



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Орчны агаарын чанарын хэмжилт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газартай хамтран дүүрэгт орчны агаарын чанарын хэмжилт хийлгэх ажлыг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2. Орчны агаарын чанарын хэмжилт хийлгэхэд холбогдон гарах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хэмжилт хийлгэхэд зарцуулагдах 384.850 (Гурван зуун наян дөрвөн мянга найман зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 03 ны өдрийн 14 дугаар
захирамжийн хавсралт



ОРЧНЫ АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ
ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэмжилт хийх үзүүлэлт	Хэмжилтийн тоо хэмжээ		Хэмжилт хийх нийт хугацаа	
1	PM _{2.5} , PM ₁₀ , SO ₂	1 цэг дээр		150.000	
Хэмжилттэй холбогдон гарах зардал					
№	Зардлын нэр	Зарцуулах зай болон хугацаа	Зарцуулах шатахууны /литрээр/	Шатахууны үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Автомашинны түлш (100км/18л) УБ хот-Багахангай-УБ	200 км	36	3850	138600
2	Моторын шатахуун (3л/1 цаг)	24 цаг	25	3850	96250
Нийт зардал					234.850
Нийт дүн					384.850